

## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ  
 /ЦАХИМ/ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС  
 ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 04 дүгээр сарын 28

Улаанбаатар хот

| ДД  | Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн<br>үйл ажиллагаа  | Үүрэг,<br>даалгавар<br>биелүүлээ<br>гүй<br>шалтгаан | Цаашид авч<br>хэрэгжүүлэх<br>арга зам          | Оноо |
|---|--|---|--|------|
| <b>Үүрэг, даалгавар-НЭГ:</b> Хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд худалдан авах ажиллагааны дагуу үнэлгээ хийгдэж байгаа ажлуудаа эрчимжүүлж ажиллах. |  |   |  |      |
| 1.  | <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/140 дүгээр захирамжаар эрх шилжин ирсэн нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 3 төсөл, арга хэмжээ, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 19, нийт 22 төсөл арга хэмжээ 2022 оны төлөвлөгөөнд тусгагдаж 100 хувь тендер зарлагдсан бөгөөд 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 04 дүгээр сарын 27-ны өдрүүдэд тендерийн үнэлгээний шатанд байсан 8 төсөл арга хэмжээний зөвлөмж, дүгнэлтийг захиалагч байгууллагуудад хүргүүлж ажилласан.</li> <li>- Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд улс, нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 87,035.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 58 төсөл, арга хэмжээ, он дамжин хэрэгжих 101,273.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 112 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс:             <ul style="list-style-type: none"> <li>- Бэлтгэл ажил хийгдэж байгаа төсөл арга хэмжээ – 47</li> <li>- Тендерийн шатандаа байгаа төсөл арга хэмжээ – 43</li> <li>- Гэрээ байгуулагдан ажил хийгдэж байгаа төсөл арга хэмжээ – 66</li> <li>- Ажил 100 хувь хийгдэж дууссан – 14</li> </ul> </li> </ul> <p>Нийт хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийн явцад тогтмол хяналт тавьж, хэрэгжилтийн мэдээг 14 хоног тутамд шинэчлэн ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хугацаанд дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон “Үнэлгээний хороо” тухай бүрт үнэлгээг хийж холбогдох дүгнэлт, зөвлөмжийг захиалагчид хүргүүлэн ажиллаж байна.</li> </ul> | =   | Үүрэг<br>даалгаврын<br>хэрэгжилт<br>хангагдана | 50   |

**Үүрэг, даалгавар ХОЁР:** Хотын соёлыг төлөвшүүлж, түгээн дэлгэрүүлэх цахим аян зохион байгуулах.

|    |  |   |  |     |
|----|--|---|--|-----|
|    |  |   |  |     |
| 2. | <ul style="list-style-type: none"> <li>- Дүүргийн Засаг даргын дэргэдэх Соёлын төвийн цахим хуудсаар дамжуулан морин хуур, төгөлдөр хуур, бүжиг, дууны дугуйлангийн сургалтыг 5 удаа зохион байгуулж, нийт 120 гаруй иргэдийн хандалт авч ажилласан байна.</li> <li>- Дүүргийн 30 жилийн ойн хүрээнд Ерөнхий боловсролын сурагчдын урлагийн авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, урлаг соёлын үйл ажиллагаагаар дамжуулан хүүхэд багачуудыг төлөвшүүлэх зорилгоор дүүргийн “Хүүхдийн урлагийн наадам-2022” арга хэмжээг 2022 оны 04 дүгээр сарын 21, 22-ны өдруүдэд 2 насны ангилалд 7 төрлөөр зохион байгуулж, нийт 18 сургуулийн 800 гаруй авьяаслаг хүүхэд багачууд хамрагдсан байна. Мөн “Хүүхдийн урлагийн наадам-2022” наадмын шилдэг үзүүлбэрүүдээр “Гала” тоглолтыг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр “Улаанбаатар театр”-т зохион байгуулж ажилласан.</li> </ul> | = | Үүрэг<br>даалгаврын<br>хэрэгжилт<br>хангагдана | 100 |

**Үүрэг, даалгавар ГУРАВ:** Хүүхдийг гэмт хэрэг, зөрчил болон зам, тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын нэгдсэн арга хэмжээг улирал бур зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

|    |  |   |  |     |
|----|--|---|--|-----|
|    | - “Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг Дэлхийн өдөр”-ийг угтан “ШИЙТГЭЛ БОЛ ШИЙДЭЛ БИШ” аяны хүрээнд хүүхдийн дуу хоолойг сонсох, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, хүүхэд хүмүүжлийн зэрэг аргын талаар гэр бүл, олон нийтийн зөв хандлагыг бий болгох чиглэлээр олон талт үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. Аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Аюулгүй зорчигч”, “Ye тэнгийн дарамт дээрэлхэлтийн серөг нөлөөлөл”, “Цахим донтолтоос сэргийлэх нь” зэрэг сэдвүүдээр өртөөчилсэн сургалтыг зохион байгуулж 1500 гаруй сурагчдыг хамруулсан. Мөн “ХҮҮХДИЙН ДУУ ХООЛОЙ-2022” V чуулганы салбар хэлэлцүүлгийг дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудад зохион байгуулж, “Хүүхдэд ээлтэй-Боловсролын үйлчилгээ”, “Хүүхдэд ээлтэй-Өрх гэр бүл”, “Хүүхдэд ээлтэй-Орон нутаг” гэсэн З салбарын хүрээнд 27,458 сурагчдаас санал хүсэлтийг нь хүлээн авч хэлэлцсэн бөгөөд Нэгдсэн чуулганыг 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Дээрх аяны хүрээнд эцэг, эх, асран хамгаалагч, олон нийтэд зориулсан “Хүүхэд хүмүүжлийн зэрэг арга”-ын талаар мэдээллийг цахимаар түгээж ажиллахын зэрэгцээ хороодын зорилтот бүлгийн иргэдэд “Хүүхэд хүмүүжлийн зэрэг арга”-ын сургалтыг танхимаар зохион байгуулж, 300 гаруй иргэнийг хамруулсан. | = | Үүрэг<br>даалгаврын<br>хэрэгжилт<br>хангагдана | 100 |
| 3. | - Замын хөдөлгөөнд явганаар оролцон, зам тээврийн осолд бага насны хүүхэд өртөж, хохирсон дуудлага мэдээлэл дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 12 бүртгэгдсэн. Зам тээврийн   |   |  |     |

|   |  |   |  |     |
|---|--|---|--|-----|
|   | осолд өртсөн хүүхдүүдийг насаар нь авч үзвэл /7-14/ насны хүүхдүүд 80 хувийг эзэлсэн тоон үзүүлэлттэй байгаа учраас Ерөнхий боловсролын сургуулиудад 3 төрлийн зөвлөмжийг 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 26л-3/116 дугаартай албан бичгээр хүргүүлж үр дүнг тооцон ажиллаж байна.   |   |  |     |
| <b>Үүрэг, даалгавар ДӨРӨВ:</b> Нийтийн эзэмшлийн гудамж талбай, автобусны буудал, гудамж, талбайн хөшөө дурсгал, сандал, хүүхдийн тоглоомын талбай, авто замын гүүрэн гарц зэрэг байгууламжуудын өнгө үзэмжийг сэргээх ажлуудаа тогтмол хийж ажиллах. |  |   |  |     |
| 4.  | <p>- Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Бүх нийтийн их цэвэрлэгээний ажил зохион байгуулах тухай А/08 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай удирдамжийн хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр дүүргийн хэмжээнд “Бүх нийтийн их цэвэрлэгээ”-ний ажлыг зохион байгуулан ажиллаа.</p> <p>Тус ажлын хүрээнд тохижилт, ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтыг сэргээх хог хаягдлыг цэвэрлэж зайлцуулах, үерийн хамгаалалтын далан суваг, зам доогуурх ус өнгөрүүлэх хоолойг цэвэрлэх, нийтийн эзэмшлийн эд хогшил, хөшөө дурсгал, авто замын төмөр болон тросон хайс хашлагыг цэвэрлэх, ил задгай хог хаягдалгүй байлгах нөхцөлийг бүрдүүлэх, байгууллагын хана, фасад, цонх, хаяг, хаягийн байгууламж, сандал, хогийн сав, үүд, довжоогоо угаах засварлах, гадна талбайгаа усалж чийгшүүлэх зэрэг ажлыг зохион байгуулан ажиллаа. Нийт 23 автобусны буудал, нийтийн эзэмшлийн нийт 953,2 м2 талбай, 10 хөшөө дурсгал, 6 бичил цэцэрлэгүүдийн өнгө үзэмжийг сэргээж угааж цэвэрлэн ажиллалаа.</p> <p>- Дүүргийн нутаг дэвсгэр дэх Нийтийн эзэмшлийн талбай болон сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхэд эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт тавьж ажиллах хуваарийг дүүргийн Засаг даргаар 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр батлуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 3/599 тоот албан бичгээр дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албад болон дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хороод нийт 108 байгууллагад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> | = | Үүрэг<br>даалгаврын<br>хэрэгжилт<br>хангагдана | 100 |
| <b>Үүрэг, даалгавар ТАВ:</b> Нийслэлийн инженерийн барилга байгууламжийн хамгаалалтын зурвасыг мөрдүүлж ажиллах, гарсан зөрчлийг арилгах, газар чөлөөлүүлэх арга хэмжээг авч ажиллах.   |  |   |  |     |
| 5.  | - Дүүргийн нутаг дэвсгэрт инженерийн барилга байгууламжийн хамгаалалтын зурваст газар олгосон, болон зөвшөөрөлгүй хашаа, хайсыг дүүргийн Засаг даргын 2020 оны А/140 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн  | = | Үүрэг<br>даалгаврын                            | 50  |

|   |  |   |  |    |
|---|--|---|--|----|
|   | хүрээнд хээрийн болон суурин судалгааг гарган холбогдох арга хэмжээг авахаар ажиллаж байна.<br>Мөн дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үерийн хамгаалалтын барилга байгууламжийн бүсэд зөвшөөрөлгүй газар шорооны ажил хийж байсан тул үйл ажиллагааг таслан зогсоож Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-т мэдэгдэн ажилласан.   |   | хэрэгжилт хангагдана                           |    |
| <b>Үүрэг, даалгавар ЗУРГАА:</b> Иргэдийн амьдрах орчныг сайжруулах, газрын зөрчил арилгах ажлын хүрээнд зөвшөөрөлгүй гарааш, хайс, хашааг буулгасан талбайг тохижуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлаа эрчимжүүлэх. |  |   |  |    |
| 6.  | - Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/388 дугаар захиралжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт 12 байршлын 168 гараашийн газрыг албадан чөлөөлөхөөр төлөвлөгдсөний дагуу 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 39 дүгээр цэцэрлэгийн урд тал, хойд талд зөвшөөрөлгүй баригдсан 34 гарааш, 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр 6 хорооны нутаг дэвсгэрт 62 дугаар байрны 20 байршлын 21 гарааш, 24 дүгээр байрны 5 гараашийг албадан буулгах арга хэмжээг зохион байгуулан ажилласан.<br>Календарьчилсан төлөвлөгөөний дагуу 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар нийт 6 байршлын 94 авто гараашийн газрын зөрчил арилгах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. | = | Үүрэг<br>даалгаврын<br>хэрэгжилт<br>хангагдана | 50 |

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Н.ХАНГАЙ

ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГА

М.НАВЧАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН  У.МАГНАЙ

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН  Д.ДОЛГОРМОАА